

ТАНИЛЦУУЛГА

”Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид багшлах эрх олгох, хасах журам”

Мэдээллийн технологи, даяарчлалын эрин зуунд дэлхий нийтийн хөгжил хурдацтай нэмэгдэхийн хирээр улс орнуудын боловсролын тогтолцоо хувьсан өөрчлөгдөж, багшид тавигдах шаардлага илүү өргөн хүрээг хамарч байна.

Олон улсын түвшинд Мэргэжлийн боловсрол, сургалтын багш нь мэргэжлийн болон сурган хүмүүжүүлэх хос үүрэг хариуцлагатай байгаа нь тэднийг хөдөлмөрийн салбарын эксперт, шинэлэг арга зүй бүхий ёс зүйтэй сурган хүмүүжүүлэгч байх шаардлагатайг харуулдаг.

Чадамжид суурилсан сургалтын онцлог, аж үйлдвэрийн IV, V хувьсгал, дижиталчлал, техник технологийн дэвшилтэй уялдан, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багшийн чадамж, үүрэг хариуцлага илүү нарийн төвөгтэй болж ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийг шаардаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний үеэр багшлах эрх олгох сургалтын агуулга, чанарыг сайжруулах, багшийн нэр хүндийг эрхэмлэх, мэргэжлийн ёс зүйг баримтлах талаар олон санал гарч хэлэлцэгдсэн. Мөн одоо мөрдөж буй Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/93 дугаар тушаалаар баталсан журмын дагуу багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагааг цаашид нэг журмаар зохицуулах боломжгүй тул “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид багшлах эрх олгох, хасах журам”-ыг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай болсон.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/176 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь зөвлөгөөний санал, холбогдох хууль дүрэмд нийцүүлэн журмын төслийг шинэчлэн боловсруулсан.

“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид багшлах эрх олгох, хасах журам”- ын төсөл нь 5 зүйл, 29 заалт, 16 дэд заалт, 2 хавсралттай.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нийцүүлэн багшлах эрх олгох зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Журмыг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчмыг хүний эрх, шударга ёс, хуулийг дээдлэх, нээлттэй байх, ашиг сонирхолоос ангид байх, багшийн тасралтгүй хөгжлийг хангах, багшийн хөдөлмөр, бие даасан байдлыг хүндэтгэх гэж тодорхойлсон.

Багшлах эрхийг тухайн багшийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр олгохоор зохицуулалт хийсэн нь сургалтын чанар, төгсөгчдийн ур чадварт эерэгээр нөлөөлнө гэж үзсэн.

Багш нарын бүртгэл мэдээллийн сан бий болгож, санд тулгуурласан системийн хяналтыг хийхээр шинэчилсэн зохицуулалт оруулсан.

Багшлах эрх олгох, хасах үйл ажиллагааны зохицуулалтууд нь багш нар ажилдаа хандах хандлагад эерэг байдлыг бий болгож, мэргэжлийн ёс зүйг баримтлах, ажил мэргэжилдээ бүтээлч эзэн нь байх, багш бие даан хөгжихөд гол нөлөөллийг үзүүлнэ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын багшийн нэр хүндийг эрхэмлэх, мэргэжлийн ёс зүйг хангуулах чухал асуудлын нэг нь багшид багшлах эрх олгох, хасах харилцааг бодитой зохицуулах явдал учраас шинэчилсэн журмыг хэрэгжүүлснээр олон талт харилцаанд ахиц өөрчлөлт бий болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

---oOo---

БАГШЛАХ ЭРХ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын багш мэргэжлээр төгсөөгүй бакалавр түүнээс дээш зэрэгтэй төгсөгч, үйлдвэрлэлийн зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй багшлах хүсэлтэй иргэнд багшлах эрх олгох, хасахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Энэхүү журмын зорилго нь сургалтын байгууллагын багшийн боловсрол, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, ёс зүй, нэр хүнд, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.
- 1.3 Багшлах эрх олгох, хасах үйл ажиллагаанд хүний эрх, шударга ёс, хууль дээдлэх, ил тод, нээлттэй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.
- 1.4 Багшлах эрх олгох, хасах үйл ажиллагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.
- 1.5 Журмын 2.1, 2.2-т заасан багш мэргэжлээр төгсөөгүй багшлах хүсэлтэй иргэнд сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллага зохион байгуулна.
- 1.6 Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллага сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлана.
- 1.7 Сургах зүйн чадамжийн гэрчилгээний /цаашид “гэрчилгээ” гэх/ загварыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын даргын тушаалаар батална.
- 1.8 Багшлах эрхийг тухайн багшийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр олгоно.
- 1.9 Багшлах эрхийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад ажиллах багшид олгоно.

Хоёр. Багшлах эрх олгох, хасах үйл ажиллагаа

- 2.1. Багшлах эрх олгох үйл ажиллагаанд хамрагдах иргэн дор дурдсан шаардлагыг хангасан байна.
 - 2.1.1 Багшаас өөр мэргэжлээр их дээд сургуулийг бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй төгсөгч байна.
 - 2.1.2 Үйлдвэрлэлийн ажлын зохих дадлага, туршлагатай мэргэжлийн өндөр зэрэгтэй ажилтан байна.
- 2.2. Сургалтын байгууллагын багш эзэмшсэн мэргэжлээс өөр чиглэлээр мэргэшихийг хүсвэл хөрвөх мэргэжлээрээ бакалаврын эсхүл мэргэшлийн өндөр зэрэг олгох сургалтад хамрагдаж төгссөн байна.
- 2.3. Журмын 2.1.1, 2.1.2, 2.2–т заасан төгсөгч, ажилтан нь сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалтад хамрагдаж, үнэлгээнд тэнцэж гэрчилгээ авсан байна.
- 2.4. Журмын 2.5, 2.6 –т заасан багшийн баримт бичгийг сургалтын байгууллагын захирал хүлээн авч багшлах эрх олгуулах, хасуулах саналаа жил бүрийн 3 дугаар сарын 30-ны дотор Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллагад цахимаар илгээнэ.
- 2.5. Багшлах эрхийн үнэмлэх авах хүсэлт гаргасан журмын 2.1.1, 2.1.2 2.1-д заасан иргэн дараах баримт бичгийг бүрдүүлж, жил бүрийн 2 дугаар сард багтаан сургалтын байгууллагын удирдлагад хүсэлтээ гаргана. Үүнд:
 - 2.5.1. Өргөдөл
 - 2.5.2. Төрийн албан хаагчийн №1 маягт бүхий анкет
 - 2.5.3. Журмын 2.2, 2.3, 2.1, 2.2–т заасан баримт бичгийн хуулбар
 - 2.5.4. 3x4 хэмжээний 2 ширхэг цээж зураг
- 2.6. Багшлах эрхийг хасах багшид дараах баримт бичгийг сургалтын байгууллагын удирдлага бүрдүүлнэ. Үүнд:
 - 2.6.1. Багшлах эрхийн үнэмлэхний эх хувь
 - 2.6.2. Багш ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн нь багшлах эрх хасах үндэслэл болохыг нотолсон баримт, хохирсон иргэний өргөдөл, тэмдэглэл, тухайн байгууллагын санал
 - 2.6.3. Сургалтын байгууллагын багш нарын ёс зүйн зөвлөлийн дүгнэлт
 - 2.6.4. Багшлах эрхийг хасах үндэслэл бүхий сургалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт
 - 2.6.5. Багшлах эрхийг 3 жил хүртэлх хугацаатай хасна. 2 удаа багшлах эрхээ хасуулсан бол багшлах эрхийг дахин олгохгүй.
- 2.7. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллага нь сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалт дууссанаас хойш сургалтын тайланг ажлын 10 хоногт багтаан мэргэжлийн

- боловсрол сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 2.8. Тухайн сургалтын байгууллага ажлын хэсэг байгуулж, журмын 2.4, 2.5 дахь хэсэгт заасан шаардлага хангасан тухай үнэлгээ, тодорхойлолтыг гаргаж албажуулна.
- 2.9. Журмын 2.8-т заасан шаардлага хангахгүй багшийн баримт бичгийг холбогдох дүгнэлтийн хамт тухайн жилийн 4 дүгээр сарын 15-ны дотор хүсэлт гаргасан багшид хүргүүлнэ.
- 2.10. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг цахимаар ирүүлсэн баримт бичигт үнэлгээ хийж, “Багшлах эрх олгох, хасах тухай” шийдвэрийн төсөл, нэрсийн жагсаалт, ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 5 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.
- 2.11. Энэ журмын 2.11-д заасан байгууллагын дүгнэлтийг үндэслэн “Багшлах эрх олгох, хасах” шийдвэрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн жилийн 6 дугаар сард багтаан гаргана.

Гурав. Багшлах эрхийн үнэмлэх нөхөн олгох

- 3.1. Багшлах эрхийн үнэмлэхээ гэмтээсэн, гэж үрэгдүүлсэн нөхцөлд дараах баримт бичгийг үндэслэн нөхөн олгож болно.
- 3.1.1 Багшлах эрхийн үнэмлэх нөхөн авах тухай иргэний хүсэлт
- 3.1.2 Журмын 2.1, 2.2–т заасан бичиг баримтын хуулбар
- 3.1.3 Багшлах эрхийн үнэмлэхийн үндсэн үнийг төлсөн төлбөрийн баримт
- 3.1.4 3x4-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг
- 3.1.5 Ажиллаж байгаа сургалтын байгууллагын тодорхойлолт
- 3.2. Багшлах эрхийн үнэмлэх нөхөн олгох үйл ажиллагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллага зохион байгуулна.
- 3.3. Багшлах эрхийн үнэмлэх нөхөн олгохдоо Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллагын багшийн мэдээллийн санг үндэслэн ажлын 21 хоногт багтаан олгоно.

Дөрөв. Багшлах эрхийн үнэмлэхийн загвар

- 4.1. Багшлах эрх авсан багшид “Багшлах эрхийн үнэмлэх” олгоно.
- 4.2. Багшлах эрхийн үнэмлэхийн нүүрэн талд “Соёмбо” тэмдэг зурж, “БАГШЛАХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ” гэж Монгол бичиг, крилл үсгээр алтан боронзоор бичнэ.

Тав. Бусад

- 5.1. Багшлах эрх олгосон, хассан багш нарын мэдээллийг бүртгэх, мэдээллийн санг үүсгэх асуудлыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн асуудал хариуцсан байгууллага хариуцна.
- 5.2. Багшлах эрх олгох, хасахтай холбоотой шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн багш холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шүүхэд хандаж болно.
- 5.3. Багшлах эрхийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэн ашиглахыг хориглоно.
- 5.4. Багшаар ажиллаж байгаад боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн байгууллагад шилжин ажилласан багшийн багшлах эрх хэвээр хадгалагдана.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2020 оны дугаар сарын
...ний өдрийн дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт*

**ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН
ХАМГААЛЫН ЯАМ**

Өмнөд бүс



Төвийн бүс

**БАГШЛАХ ЭРХИЙН
ҮНЭМЛЭХ**





Үнэмлэхийн дугаар:
МБС-.....

Овог:

Нэр:

“Багшид багшлах эрх олгох тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 20... оны ...-р сарын ... ны өдрийн дугаар тушаалыг үндэслэв. Мэргэжлийн боловсролын салбарт мэргэжлийн чиглэлээр багшлах эрх олгов.

ХОДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН

Сайд _____
(Тэмдэг)

Олгосон: 20..... оны сарын өдөр



Тайлбар: Үнэмлэхийн дугаарын кодлолт
 МБ - 20 145 131
 МБ- мэргэжлийн боловсрол
 20 – тушаал батлагдсан оны сүүлийн 2 орон
 145 – тушаалын дугаар
 131 – бүртгэлийн дугаар